



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 5/15

Чингис хот

Т.Баяртуяаг үргэлжлүүлэн ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.2.4, 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ангилал, зэрэглэл”, 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”, 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэнтий Нийтлэг үйлчилгээ” ОНӨҮГ-аас цалинжуулан няраваар ажиллуулж байсан Төмөрбаатарын Баяртуяаг аймгийн Засаг даргын Тамгын газрын няравын ажилд нь 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2. Т.Баяртуяагийн сарын үндсэн цалинг ТҮ-4-5 шатлалаар тогтоон, 590937 /таван зуун ерэн мянга есөн зуун гучин долоо/ төгрөгөөр, ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Т.Баяртуяад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030063